

Багшийн арга зүй суралцагчдын зөв бичих чадварт нөлөөлөх нь

Н.Даваасүрэн*

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,

Багшийн сургууль, Бага боловсролын монгол хэл, нийгмийн ухааны тэнхим

Хураангуй

Хүн төрөлхтний хэл нь давхарлан шаталж тогтсон нэгжүүдтэй, бүхэл бүтэн тогтолцоо бөгөөд нэгэнт хэл нь тогтолцоот шинжтэй, дүрэм нь тогтолцоот чанартай бол түүнийг зааж сургах арга зүй нь мөн тогтолцоот байх нь зайлшгүй болж байна. Тиймээс бид зөв бичих дүрмийг тогтолцоот шинжид нь тулгуурлан заах арга зүйн нэг хувилбар нь зөв бичих дүрэм хооронд үүсэх "эргэх холбоонд" тулгуурлан заах арга зүй байж болох юм гэж үзсэн болно. Бидний судалснаар кирилл бичгийн аль нэг зөв бичих дүрмийг заах явцад түүнд холбогдох бусад дүрмүүд 2-17 удаа давтагдан, дүрэм хооронд "эргэх холбоо" үүсэж, улмаар дүрэм хоорондын уялдаа холбоог илүү тодотгодог байна. Бид энэхүү арга зүйгээ 2017-2018 оны хичээлийн жилд Багшийн сургуулийн I дамжаанд үзэх "Авиа зөв дуудах, зөв бичих зүй" хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ туршсан болно. Бид, сонгон хэрэгжүүлсэн арга зүйгээ хэр өгөөжтэй байсныг тодруулах судалгааг зориудаар, туршилт- сургалт дууссанаас хойш 5 сарын дараа буюу 2018. 10. 12-ны өдөр авсан бөгөөд туршилт- сургалтад хамрагдсан 120 оюутнаас санамсаргүй түүврийн аргаар 33 оюутныг сонгосон болно. Энэхүү судалгааг "Авиа зөв дуудах, зөв бичих зүй" хөтөлбөрийн үр дүнд суралцагчдад төлөвшөл зохих "зөв бичих дүрмийг үндэслэлтэй тайлбарлаж сурах, буруу, зөв бичсэн үгийг ялган таних, засах, алдаагүй зөв бичих, улмаар заан сургах түвшинд зөв бичих дүрмийг "өөрийншүүлэх" зэрэг 15 чадварыг илрүүлэх зорилготой "Багц даалгавар"-аар авсан юм. Багц даалгаврын үнэлгээний дундаж оноо 71 (С-) байгаа нь өнгөц харахад төдийлөн хангалттай биш боловч нэг талаас 16 цагийн буюу 8 удаагийн семинар хичээлийн үр дүн, нөгөө талаас хичээл сургалт дууссанаас хойш 5 сарын дараах үнэлгээ болохын тухайд "хангалттай үнэлгээ" болно. Энэхүү судалгаа нь багшийн оновчтой чиглүүлэг буюу арга зүй суралцагчдын суралцахуйг өөрчлөхөд тодорхой дэмжлэг болохыг нотлохын зэрэгцээ зөв бичих дүрмийг хоосон цээжлүүлэх, тус тусад нь салангид заахаас татгалзаж, зөв бичих дүрэм хоорондын, дүрмийн зүйл хоорондын харилцан хамаарал, "эргэх холбоо"-нд тулгуурлан заах нь суралцагчдын зөв бичих дүрмийн мэдлэгийг улам батжуулж, дүрэм тус бүрийн мөн чанар ухааруулж, улмаар чадвар, дадал болгох боломжтойг баталж байна.

Түлхүүр үг

Зөв бичих дүрэм, интеграци, дүрмийн давтамж, эргэх холбоо

Удиртгал

Хэл нь оюун ухаан, танин мэдэхүйн чухал зэвсэг, нийгмийн түүх, туршлагыг баяжуулан өвлүүлэгч, хүнийг нийгэмшүүлэх хэрэгсэл болдог бөгөөд эх хэлээ сурч эзэмших, сургаж эзэмшүүлэх нь улс үндэстэн, нийгэм, бие хүний хувьд амьдралын зайлшгүй хэрэгцээ мөн. Энэхүү хэрэгцээг хангахад утга зохиолын хэл нэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ тухай академич Ш. Лувсанвандан "Хэл шинжлэлд утга зохиолын хэл гэдэг нь ... ер бичгийн хэлийг хэлдэг байна. Утга зохиолын хэл нь ... хэчнээн нэгдмэл байвал зорилгоо төчнөөн сайн биелүүлнэ. Энэ ч учраас аль ч үндэстний утга зохиолын хэл нь нийгмийн харилцахын хэрэглүүр болох явцдаа хэлний зүйн байгуулал, үгсийн үндсэн сан, дуудах аялгуу,

тэмдэглэх үсгийн дүрмийн талаар улам улам нэгдмэл шинжтэй болж иржээ." (1953, х.43) гэж тэмдэглэснээс үзвэл бичгийн хэл нь нэгдмэл үсгийн дүрэмтэй байж сая харилцааны хэрэглүүр болж чаддаг байна. Академич Б.Ринчен "Бичгийн хэл" өгүүлэлдээ "Бичгийн хэл нь тэгш хэрэгцээтэй, нарийн боловсруулсан хэмжээ, журамтай..." гэсэн нь мөн л зөв бичих хэм хэмжээтэй байх тухай өгүүлсэн хэрэг. Академич Ш.Лувсанвандан "... Монгол бичгийн хэлэнд сайн сурч эзэмшихэд унших, бичих хоёрыг сайн хослуулах хэрэгтэй. Монгол бичгийн хэлэнд сайн сурах гэдэг нь бичиг зохиолыг уншаад сайн ойлгож сурах, бичгийн хэлийг сайн эзэмших гэдэг нь санасан бодсоноо бичгээр сайхан гаргаж

✉ ndavaasuren@msue.edu.mn

сурахыг хэлнэ” (1980, х. 42) гэжээ. Бичгээр сайхан гаргаж бичнэ гэдэг нь утгаа бичгийн хэлний хэм хэмжээнд, бүр тодруулбал, зөв бичих хэм хэмжээнд суралцах гэсэнтэй утга дүйж байна.

Доктор(Sc.D)Ц.Оюун “Хэл,соёлсэтгэлгээ” номдоо “Бичгийн хэлэнд тавих шаардлагыг бичгийн хэлний соёлын хэмжүүр хэмээн үзнэ. Бичгийн соёлтой хүн дараах шаардлагыг хангаж бичсэн байдаг. Энэ нь алдаагүй зөв бичих, гаргацтай сайхан бичих, үгээ зөв сонгож, утга төгс бичих, учир шалтгааны үндэстэй оновчтой найруулж бичих....” гэх мэт 7 зүйлийг дурдаад, бичгийн соёлын нэг гол зарчмыг утга зохиолын хэлэнд зөв бичих зүйн хэм хэмжээгээр тогтоох тул зөв бичих дүрмийн дагуу бичихийг, цэвэр үзэмжтэй, алдаагүй, ойлгомжтой, утга төгс бичиж сурах гэсэн бичгийн нэгдсэн шаардлага монгол хэлний сургалтад тавигдсаар ирснийг, өнөөдөр ч энэ шаардлага монгол хэлний боловсролын хэрэгцээ болсон хэвээр байгааг онцолжээ (2018, х. 111). Нөгөө талаас 21-р зууны суралцагчийн эзэмших чадварын нэг бол эх хэлний чадамж болохыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөөд байна.

Тухайлбал, Европын Парламент, Боловсролын зөвлөлөөр 2016 оны 12-р сард батлагдсан санал зөвлөмжид насан туршдаа суралцах найман үндсэн чадамжийн нэгээр “эх хэл дээрээ харилцах” чадамжийг нэрлэсэн байна (Ариунжаргал, ба бус, 2018, х.11). Мөн 2020 оны багшлахуйн ба суралцахуйн чиг хандлагыг тандан судалсан судлаачдын баг мэдлэгт суурилсан эдийн засаг бүхий технологижсон нийгэмд амьдрахад дараах уян чадвар (soft skills) эзэмших шаардлагатай байгааг”-г тогтоосны эн тэргүүнд “ам, бичгээр өндөр түвшинд харилцах чадвар” дурджээ. (Ариунжаргал, ба бус, 2018, х 19) Энэ бүхнээс үзвэл монгол хэлээр хэлэлцэгч хэн бүхэн бичгийн хэлээр харилцахын тулд зөв бичих хэм хэмжээг баримтлах шаардлагатай болж, бичгийн хэлэнд суралцъя гэвэл зөв бичих чадвартай байх ёстой байна. Монгол хэлээр хэлэлцэгч хэн бүхний эх хэлний чадамж ямар түвшинд байгааг, ямар түвшинд эзэмшсэнийг буюу бичгээр харилцах чадварын түвшинг тодорхойлох нэг том хүчин зүйл зөв бичих чадвар болж байна. Тийм ч учраас сүүлийн жилүүдэд монгол хэлний зөв бичих дүрмийг тойрсон маргааныг шийдвэрлэх зорилго хууль, дүрэм, шийдвэр, тогтоол нэлээдгүй гарчээ. Тодруулбал, 2004 онд Засгийн газрын 67-р тогтоолоор Төрийн хэлний зөвлөлийг байгуулж, тус зөвлөлийн “Кирилл бичгийн стандарт тогтоох тухай” 01 тоот тогтоол (2011.10.05)- оор

олон хувилбар бичлэгтэй 700 үгийн журамласан жагсаалтыг баталж, МУ-ын Засгийн газрын баталсан “Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай” 37 дугаар тогтоол (2013.02. 02)- ын хүрээнд төрийн ба төрийн бус байгууллагуудын албан хаагчдад зөв бичих дүрмийн сургалт явуулж, ЭЕШ-ын журамд өөрчлөлт оруулан, элсэгчид ЭЕШ-д орохоос өмнө монгол хэл, бичгийн шалгалт заавал өгч, уг шалгалтад тэнцсэнээр цаашид оюутан болж суралцах эрх авах ЭЕШ-д ордог болов. 2013 оны 07 сарын 1-нээс мөрдөж буй “Төрийн албаны мэргэжлийн шалгалтын шинэчлэгдсэн журам”-ын дагуу төрийн албаны шалгалт өгөх иргэд монгол хэл бичгийн шалгалт өгөх боллоо. Улмаар МУ-ын Засгийн газар 2015 оны 2-р сарын 12-ны өдөр “Монгол хэлний тухай хууль”-ийг батлан, 2015 оны 7 сарын 1-ний өдрөөс мөрдөж эхлээд байгаа бөгөөд энэхүү хуулийн хүрээнд Монгол Улсын ерөнхийлөгчийн дэргэд байгуулагдсан “Хэлний бодлогын үндэсний зөвлөл” - өөс эрхлэн гаргасан “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь”-ийг тус зөвлөлийн 2018 оны 07 сарын 06-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталж, бүх нийтээр дагаж мөрдөхөөр болов. Үүний хамт бичгийн харилцаан дахь зөв бичих дүрмийн алдааг багасгах, урьдчилан сэргийлэх зорилготой зөв бичих дүрмийн алдаа шалгах программууд зохиогдон, олны хүртээл болсоор байна. Өнөөдөр, хууль эрх зүйн талаас утга зохиолын хэлний зөв бичих хэм хэмжээг баримтлахыг шаардаж, мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачид олон талт ажлыг зохион байгуулж, бид хуульчлан батлагдсан зөв бичих дүрэмтэй, зөв бичих дүрмийн тольтой, алдаа шалгах программтай болсон байна.

Ийнхүү зөв бичих боломж хэн бүхний өмнө нээлттэй болсон энэ цагт багш, сурган хүмүүжүүлэгчид бид суралцагчдаа алдаагүй, зөв бичүүлж сургахын тулд юу хийх ёстой вэ? гэдэг асуудал бидний өмнө тулгарч байна. Тодруулбал, цаг үе, биднээс суралцагчдын зөв бичих чадварыг сайжруулах, зөв бичих дүрмийг зааж сургах арга зүйдээ шинэчлэл хийхийг сануулж байна. Тэгэхээр XXI зууны иргэдийн зайлшгүй эзэмших чадварын нэг болох “эх хэлний чадамж буюу ам, бичгээр өндөр түвшинд харилцах чадвар”-тай иргэдийг бэлтгэхэд гол үүрэгтэй оролцох ирээдүйн бага боловсролын багш - өнөөгийн суралцагч өөрөө энэхүү чадварыг өндөр түвшинд эзэмшсэн байх нь гарцаагүй. Чухам энэ зорилгын үүднээс бид суралцагчдын зөв бичих чадварыг сайжруулахад багшийн арга зүй нөлөөлөх боломжтой гэж үзэн, энэ сэдвийг сонгон судалсан юм.

Үндсэн хэсэг

Хүн төрөлхтний хэл нь давхарлан шаталж тогтсон нэгжүүдтэй, бүхэл бүтэн тогтолцоо бөгөөд түүний өнгөн бүтэц болох бичиг, түүнийг зөв бичих зүй тогтол ч мөн тогтолцоот чанартай юм. Гэвч нарийн тогтолцоотой зөв бичих дүрмийг ЕБС-д нэгдсэн тогтолцоогүйгээр, увуу цувуу, хэсэг бусгаар үзэж, тэр хэмжээгээр анги ангийн сурах бичигт цацаж оруулснаас (Оюун, 2018, х.72) суралцагчид зөв бичих дүрмийн цогц мэдлэггүй, дүрмээ цээжээр хэлж чаддаг ч хэрэглээ болгоогүй, зөв бичих дадалд суралцахгүй байна гэж бид үзэж байна. Нэгэнт хэл нь тогтолцоот шинжтэй, дүрэм нь тогтолцоот чанартай бол түүнийг зааж сургах арга зүй нь мөн тогтолцоот байх нь зайлшгүй болж байна. Ийм учраас бид, кирилл бичгийн зөв бичих дүрмийг харилцан хамаарал, уялдаа холбоо, харьцаагаар нь интеграцчилан заах боломж байна гэж үзэн, бага боловсролын багш бэлтгэх монгол хэлний сургалтад туршин хэрэгжүүлсэн болно. Бидний судлан тогтоосноор монгол хэлний 64 зүйл дүрмийн 45 нь буюу 70 % балархай эгшгийн эгшигжүүлэх, ялгах, зөөлрүүлэх үүрэгтэй шууд ба дам холбоогоор интеграцчилагдаж байсны 32 дүрэм буюу 71.1 % нь шууд холбоогоор, 13 дүрэм буюу 28.9 % нь дам холбоогоор интеграцчилагдаж байсан юм. Тодруулбал, балархай эгшгийн эгшигжүүлэх үүрэг буюу “Эгшигт гийгүүлэгчийн дүрэм (§16), заримдаг гийгүүлэгчийн дүрэм (§17, 18), түүний гажилтад нийт 12 дүрмийн 25 зүйлийг нэгэн багц болгон интеграцчилах боломж байгаа бол балархай эгшгийн ялгах үүрэгт 7 дүрмийн 10 зүйлийг, балархай эгшгийн зөөлрүүлэх үүрэгт 10 дүрмийн 10 зүйлийг интеграцчилах боломжтой нь ажиглагдсан юм. Ийнхүү нэг дүрмийг заах таниулахдаа нэг дор 3-7 дүрмийг багцалснаар нэг дүрмийг тойрсон “дүрмийн бүлэг” үүсэж, улмаар

зөв бичих дүрэм, тус бүрийн мөн чанар ухагдан, зөв бичих дүрмийн “ухамсартай мэдлэг”-тэй болж, дүрмийн мэдлэгээ чадвар, чадвараа дадал хэрэглээ болгох боломжтой гэж бид үзсэн бөгөөд энэ нь бидний туршилт- сургалтын үр дүнгээр нотлогдож, үр дүнг өмнөх хурлуудаар хэлэлцүүлсэн билээ.

Кирилл бичгийн зөв бичих дүрмийг ийнхүү дотоод уялдаа холбоогоор нь интеграцчилан заах явцад нэгэн сонирхолтой зүйл ажиглагдсан нь зөв бичих дүрмийн хооронд үүсэх “**эргэх холбоо**” юм. Тодруулбал, тухайн дүрэмтэй интеграцчилагдаж байгаа дүрмийн аль нэгийг заан таниулахад бусад дүрэм, түүний зүйл дахин давтагдаж, дараагийн дүрмийг заахад мөн тэдгээр дүрэм, дүрмийн зүйл дахин давтагдах зэргээр дүрмүүд хэд хэд давтагддаг байна. Энэхүү зүй тогтлыг бид “ дүрмийн эргэх холбоо” гэж нэрлэж байгаа бөгөөд зөв бичих дүрмийг ийнхүү “эргэх холбоо”-нд нь зааснаар суралцагчид зөв бичих дүрмийг хоосон цээжлэх биш, харин цэгцтэй, ухамсартай, гүн бат мэдлэг болон бууж, чадваржсан мэдлэг, дадал болон хувирч, улмаар “ам ба бичгээр өндөр түвшинд харилцах чадвар”-тай болоход зохих дэмжлэг үзүүлэх боломжтой гэж үзсэн билээ.

Кирилл бичгийн зөв бичих дүрмийн хооронд эргэх холбоо хэрхэн үүсэхийг үзүүлсэн дараах хүснэгтээс “-ж, -ч” нөхцөлийг бичих дүрэм” (§40), “ Заримдаг гийгүүлэгчийн дүрэм” (§18), “ж, ч, ш –ийн дараах эгшгийг зөв бичих дүрэм” (§27), “Зөөлний тэмдэг “и” болох дүрэм” (§32) дүрмүүдийн аль нэгийг заахад бусад 3 дүрэм, түүний зүйл дахин давтагдаж, тэдгээр дүрмийн хооронд “эргэх холбоо” үүсдэгийг тодорхой харж болно. Үүнд:

Хүснэгт 1

“-ж, -ч” нөхцөлийг зөв бичих дүрэмд (§ 40) эргэх холбоо үүсэх нь


Дүрэм	Дүрмийн зүйл	Жишээ	Эргэх холбоо үүсэх дүрэм, дүрмийн зүйл
Заримдаг гийгүүлэгчийн дүрэм (§ 18)	Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад сүүлийн заримдаг гийгүүлэгч өмнөө ба хойноо эгшигтэй бичнэ.	1. дас+ж = дасАж, уулз+ж = уулзАж 2. унц+ж = унцИж, түш+ж = түшИж 3. ахь+ж = цахИж, дох+ж = дохИж	1.Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд зөвхөн “-ж” бичнэ. (§ 40.2) 9+ж (2) 2.Эр, эм ямар ч үгийн дунд ж, ч, ш гурвын дараа дараа эгшиг бичиж шаардлага гарвал зөвхөн “и” бичнэ. (§ 40.2) Үгийн дунд ж, ч, ш +И (2) 3.“Зөөлөрсөн заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад зөөлний тэмдэг “и” болж солигдоно. (§ 32.4) 9б+ж=И (2)

“-ж, -ч” нөхцөлийг бичих дүрэм” - (§ 40)	Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд зөвхөн “-ж” бичнэ. (§ 40.2) 9+ж (1)	1. дас+ж = дасАж, уулз+ж = уулзАж 2. унш+ж = уншИж, түш+ж = түшИж 3. ахь+ж = цахИж, дохь+ж = дохИж	1.Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад сүүлийн заримдаг гийгүүлэгч өмнөө ба хойноо эгшигтэй бичнэ. (§ 18) 9+9= Э (2) 2.Эр, эм ямар ч үгийн дунд ж, ч, ш гурвын дараа дараа эгшиг бичих шаардлага гарвал дандаа “и” бичнэ. (§ 27.3) Үгийн дунд ж, ч, ш +И (3) 3. Зөөлөрсөн заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад зөөлний тэмдэг “и” болж солигдоно. (§ 32.4) 9ь+9=И (3)
ж, ч, ш гийгүүлэгчийн дараа эгшигийг зөв бичих дүрэм (§ 27)	“Эр, эм ямар ч үгийн дунд ж, ч, ш гийгүүлэгчийн дараа эгшиг бичих шаардлага гарвал дандаа “и” эгшиг бичнэ. (§ 27.3) Үгийн дунд ж, ч, ш +И (1)	турш+ж = туршИж, түш+ж = түшИж	1. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад сүүлийн заримдаг гийгүүлэгч өмнөө ба хойноо эгшигтэй бичнэ. (§ 18) 9+9= Э (3) 2.Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд зөвхөн “-ж” бичнэ. (§ 40.2) 9+ж (3)
“Зөөлний тэмдэг “и” болох дүрэм (§ 40)	“Зөөлөрсөн заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад зөөлний тэмдэг “и” болж солигдоно. (§ 32.4) 9ь+9=И (1)	цахь+ж = цахИж, дохь+ж = дохИж	1.Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад сүүлийн заримдаг гийгүүлэгч өмнөө ба хойноо эгшигтэй бичнэ. (§ 18) 9+9= Э (4) 2.Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд зөвхөн “-ж” бичнэ. (§ 40.2) 9+ж (4)


Ийнхүү дээрх 4 дүрмийн аль нэгийг заахад бусад дүрэм, түүний зүйл 3-4 удаа давтагдан, (дүрмийн давтамжийг 1-4 тоогоор дугаарлав.) зөв бичих дүрмийн эргэх холбоо үүсэх ба тэр хэмжээгээр дүрмийн мэдлэг гүн бат болж, зөв бичих чадвар, дадал болоход нөлөөлөх нь боломжтой. Кирилл бичгийн бусад зөв бичих дүрэмд ч ийм “эргэх холбоо” үүсдэгийг дараах 3 загвараар төлөөлүүлэн үзүүлье. (Сумаар дүрэм хоорондын эргэх холбоог тэмдэглэв.)

Загвар 1

Эгшигт гийгүүлэгчийн дүрэмд холбогдох дүрмийн эргэх холбоо




Загвар-2. Хамааруулах “-х” дагаврыг бичих дүрэмд холбогдох дүрмийн эргэх холбоо



Загвар 3

Зөөлний тэмдэг үл солигдох дүрэмд холбогдох дүрмийн эргэх холбоо



Энэчлэн кирилл бичгийн зөв бичих дүрэмд үүсэх “эргэх холбоо”-г бүртгэвэл аль нэг дүрмийг заах явцад түүнд холбогдох бусад дүрмүүд 2-17 удаа давтагдан, дүрэм хоорондын уялдаа холбоог бүр илүү тодотгодог байна. Тэдгээрээс “Утгат хэсгийг зөв бичих дүрэм”, “Эгшиг зохицох ёс” дүрэм нь бидний сонгосон дүрэм бүрд давтагдаж байгаа нь зөв бичих дүрмийн алдаанд багагүй хувийг эзэлдэг үгийн язгуур үндсэнд залгавар залгахдаа бүтээврийн бүтцийг эвдэж бичих, эр, эм үгэнд эр, эм үгийн залгавар хольж бичих зэрэг алдаанаас сэргийлэх боломж олгож байна.

Зөв бичих дүрэм хооронд үүсэх давтамж буюу “эргэх холбоо”-г бүртгэн, хүснэгтээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт 2

Зөв бичих дүрмийн эргэх холбоо ба дүрмийн давтамж

	ЭГД	ЗГД	Б-И	Б-Ь	“-л”	“-лга”	“-ж, -ч”	Ж, ч, ш	Б, в	“-х”	ЯЭ	Д-2	Д-3	УХ	ЭЭЁ	“-ий, -ы”	СҮ	ГЭГ	нийт
ЭГД			+		+	+		+			+		+	+	+			+	9
ЗГД			+	+			+	+		+	+			+	+			+	8
Б-И	+	+			+	+	+					+		+	+	+		+	8
Б-Ь		+					+							+	+				4

“-л”	+		+					+						+	+				5
“-лга”	+		+											+	+				4
“-ж, -ч”		+	+	+				+						+	+				6
Ж, ч, ш	+	+			+		+			+			+	+	+	+			8
Б, в														+	+		+	+	3
“-х”		+						+						+	+				2
ЯЭ	+	+										+	+	+	+	+		+	6
Д-2			+								+			+	+				3
Д-3	+							+			+			+	+			+	4
УХ	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+		+	+	+	+	17
ЭЗЭ	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+		+	+	+	17
“-ий, -ы”			+					+			+			+	+				5
СҮ									+					+	+				3
ГЭГ	+	+	+	+					+		+		+	+	+				7
нийт	9	8	8	4	5	4	6	8	3	2	6	3	4	17	17	5	3	7	

Товчилсон үгийн тайлбар:

1. ЭГД-эгшигт гийгүүлэгчийн дүрэм
2. ЗГД - заримдаг гийгүүлэгчийн дүрэм
3. Б-И – зөөлний тэмдэг “и” болох дүрэм
4. Б-Б – зөөлний тэмдэг үл солигдох дүрэм
5. “-л” - үйл үг бүтээх “-л” дагаврын дүрэм
6. “-лга, -лго” - нэр үг бүтээх “лга, -лго” дагаврыг бичих дүрэм
7. “-ж, -ч” нөхцөлийг зөв бичих дүрэм
8. Ж, Ч, Ш – ж, ч, ш-ийн дараах эгшгийг зөв бичих дүрэм
9. Б, В - б, в үсгийг ялган бичих дүрэм
10. “-х” - хамааруулах “-х” дагаврыг зөв бичих дүрэм
11. ЯЭ- ялгах эгшгийн дүрэм
12. Д-2 - дараалсан 2 гийгүүлэгчийн дүрэм
13. Д-3 – дараалсан 3 гийгүүлэгчийн дүрэм
14. УХ – утгат хэсгийг бичих дүрэм
15. “-ий, -ы” - “-ий, -ы”-г бичих дүрэм
16. СҮ – сул үгийг бичих дүрэм
17. ГЭГ – гээгдэх эгшгийн дүрмийн гажилт

Ийнхүү зөв бичих дүрмийг “эргэх холбоо”-нд нь тулгуурлан зааснаар зөв бичих дүрэм бүрийн мөн чанарыг ухаарч, түүнд холбогдох жишээ баримтыг ялган таньдаг, буруу бичсэн үгийг дүрмээр тайлбарлан засаж чаддаг, зөв буруу бичсэн үгийг ялган таньдаг, ижил дүрмээр бичсэн үгийг алгадаг, зөв бичсэн үгийг холбогдох дүрмээр тайлбарлан нотолж чаддаг зэрэг чадварт суралцах юм.

Бид, зөв бичих дүрмийг, дүрэм хоорондын энэхүү эргэх холбоонд тулгуурлан зааснаар суралцагчдын зөв бичих чадварт тодорхой

ахиц гарах боломжтой гэж үзэн, 2017-2018 оны хичээлийн жилд Багшийн сургуулийн I курсийн II улиралд үзэх “Авиа зөв дуудах, зөв бичих зүй” хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ энэхүү арга зүйг зөв бичих дүрмийг интеграцчилан заах арга зүйтэй хослуулан, сургалтаа явуулсан болно. Сургалтын явцад суралцагчдын зөв бичих дүрмийн мэдлэг, чадвар, дадалд чамгүй ахиц гарч байсан нь бидний таамаглал үнэн болохыг нотолж байна гэж үзсэн юм. Бид, сонгон хэрэгжүүлсэн арга зүйгээ хэр өгөөжтэй байсныг тодруулах, үр дүнд суурилсан сургалт явуулж чадсан эсэхээ нягтлах, суралцагчдад гарсан ахицыг үнэн бодит эсэхийг нотлох зорилгоор туршилт- сургалтад хамрагдсан 120 орчим оюутнаас 33 оюутныг санамсаргүй түүврийн аргаар сонгон, судалгаа авсан юм.

Бид, сургалтынхаа үр дүнг буюу суралцагчдын зөв бичих чадварыг зөвхөн цээж бичгээр, зөвхөн дүрэм мэддэг байхаар, дүрмээ цээжээр хэлж чаддаг байхаар тодорхойлохоос татгалзаж, зөв бичих дүрмийг үндэслэлтэй тайлбарлаж сурах, буруу зөв бичсэн үгийг ялган таних, засах, алдаагүй зөв бичих, улмаар заан сургах түвшинд зөв бичих дүрмийг “өөрийншүүлэх” зэрэг чадвараар илрүүлэхийг хичээсэн. Бидний сонгосон үнэлгээний даалгавар нь “Авиа зөв дуудах, зөв бичих зүй” хөтөлбөрийн үр дүнд суралцагчдад төлөвшөл зохих доорх 15 чадварыг илрүүлэх зорилготой “Багц даалгавар” байсан бөгөөд энэхүү судалгааг зориудаар, туршилт- сургалт дууссанаас хойш 5 сарын дараа буюу 2018.10.12-ны өдөр авсан юм.

Хүснэгт 3

Суралцагчдын мэдлэг, чадвар, дадлыг харьцуулсан нь (Туршилтын ба өөр арга зүй)

Дундаж оноо	Оюутны тоо					Зөв бичих дүрмийн мөн чанарыг ойлгох чадварыг тандах багц даалгавар	Зөв бичих дүрмийн мэдлэгээ хэрэглэх чадварыг тандах багц даалгавар					Зөв бичих дүрмийн мэдлэгээ дадал, хэрэглээ болгосон байдлыг тандах багц даалгавар					Нийт оноо						
	Зөв бичих дүрмийн уялдаа холбоог тайлбарлах	Зөв бичих дүрмийн эргэх холбоог тодорхойлох	Зөв бичих дүрмийн зөв, буруу ойлголтыг ялгах	Адил төстэй дүрмийн ялгааг тайлбарлах	Зөв бичих дүрмийн дэс дарааг ялган тогтоох		Үнэлгээ / оноогоор/	Зөв бичих дүрэмд тохирох жишээг зөв сонгох	Дүрэм ба жишээг зөв таних, харшалзуулах	Бүтээврийн зааг дахь дүрмийг тайлбарлах	Ижил дүрмээр бичсэн үгийг ялгах	Тодорхой дүрмээр бичсэн үгийг ялгах	Үнэлгээ / оноогоор/	Зөв бичсэн үгийг ялган таних	Буруу бичсэн үгийг ялган таних	Зөв бичсэн үгийг дүрмээр тайлбарлан багтах		Адил хэлбэртэй ч өөр дүрмээр бичсэн үгийг ялгах	Буруу бичсэн үгийг дүрмээр тайлбарлан засах	Үнэлгээ / оноогоор/			
	Авах оноо					100	Авах оноо					100	Авах оноо					100	нийт				
16.6	24	24	24	14	14	70.3	18	18	28	18	18	72.6	18	18	28	18	18	100	71				

Товчилсон үгийн тайлбар: ТАЗ –туршсан арга зүй:

Хэдийгээр энэхүү үнэлгээ өнгөцхөн харахад төдийлөн хангалттай биш харагдавч нэг талаас 16 цагийн буюу 8 удаагийн семинар хичээлийн үр дүн, нөгөө талаас хичээл сургалт дууссанаас хойш 5 сарын дараах үнэлгээ болохын тухайд “хангалттай үнэлгээ” гэж үзэж байна. Учир нь “Авиа зөв дуудах, зөв бичих зүй” хөтөлбөр нь “авиа зүйн онол+ зөв бичих зүй” гэсэн үндсэн агуулгатай байдаг бөгөөд зөв бичих зүйн ойлголтыг нийт цагийн 50 хувьд буюу 16 цагийн семинар, 4 цагийн лекц хичээлээр ордог юм. Нөгөө талаас энэхүү судалгаагаар багш, хичээл сургалтаа хөтлөн явуулах арга зүйгээ өөрчилснөөр суралцагчдын мэдлэг, чадвар, дадлыг давхар өөрчлөх боломжтойг нотлохыг чухалчилснаа онцолж байна. Өөрөөр хэлбэл, зөв бичих дүрмийг “эргэх холбоо”-нд нь заах арга зүйг, интеграцчилан заах арга зүйтэй хослуулснаар суралцагчдын зөв бичих дүрмийн мэдлэг цэгцэрч, тэр хэрээр зөв бичих дүрмээ чадвар, дадал болгож байгаа нь

харагдаж байна. Энэ нь нэг талаас багшийн оновчтой чиглүүлэг буюу арга зүй суралцагчдын суралцахуйд дэмжлэг болохыг нотолж байгаа ч нөгөө талаас суралцагчдын өөрсдийн бүтээлч хандлага, сурлагын амжилтаа өөрөө удирдан, тасралтгүй ахиулах, өөрийн сурах үйлд гарч буй ахицаас урамших, өөрийн хяналттай суралцах, бусдаас суралцах буюу өөрийн зохицуулалттай суралцсаных нь үр дүн байсан гэдгийг онцлон тэмдэглэж байна.

Дүгнэлт

Суралцагчдын эх хэлний чадамжийг, тэр дундаа зөв бичих чадварыг сайжруулахын тулд зөв бичих дүрмийг хоосон цээжлүүлэх, тус тусад нь салангид заахаас аль болох татгалзаж, зөв бичих дүрмийг харилцан уялдаат шинжид нь тогтолцоот чанарт нь, эргэх холбоонд нь тулгуурлан заах боломжтой байна. Өөрөөр хэлбэл, зөв бичих дүрэм хоорондын, дүрмийн зүйл хоорондын харилцан уялдаат шинж, харилцан хамаарал, “эргэх холбоо”-нд тулгуурлан

зааснаар суралцагчдын зөв бичих дүрмийн мэдлэг улам батжин, дүрэм тус бүрийн мөн чанар ухагдан, зөв бичих дүрмийн ухамсартай, гүн бат мэдлэгтэй, нэгэн цогц, нэгэн “бүхэллэг”, нэгэн цул ойлголттой болж, тэрхүү “ухамсартай” мэдлэг улмаар чадвар болж, чадваржсан мэдлэг дадал болсоор суралцагчийн “хур туршлага” буюу мэдлэг, чадвар, дадал өөрчлөгддөг байна.

Ном зүй

- Ариунжаргал, Д. ба бус. (2018). Суралцахуй, суралцахуйн хэв маяг. Улаанбаатар
Даваасүрэн, Н. (2016). Кирилл бичгийн зөв бичих дүрмийг заах арга зүйн нэг хувилбар. Сургуулийн өмнөх болон бага боловсролын асуудал, шийдэл. ОУЭШХ. Улаанбаатар, х. 212-221
Даваасүрэн, Н. (2017). Суралцагчдын зөв бичих чадварыг интеграцчилан заах арга зүйгээр

дэмжих боломж ба судалгааны үр дүн. Боловсролын чанар-үр дүн. ОУЭШХ. Улаанбаатар, х. 64-70

- Даваасүрэн, Н. (2018). Зөв бичих дүрмийг интеграцичлан заах арга зүй, суралцагчдын зөв бичих чадварт нөлөөлсөн нь. Боловсролын чанар-үр дүн. ОУЭШХ. Улаанбаатар, х.385-391
Дамдинсүрэн, Ц., Осор, Б. (1983). Монгол үсгийн дүрмийн толь. Улаанбаатар
Лувсанвандан, Ш (1953). Орчин цагийн монголын утга зохиолын хэлний онцлог нь. “Шинжлэх ухаан” сэтгүүл, №2. Улаанбаатар, х.43
Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь, (2018). Улаанбаатар
Оюун, Ц. (2018). Зөв бичгийн дүрмийн тогтолцоот хураамж. Улаанбаатар
Оюун, Ц. (2019). Хэл, соёл, сэтгэлгээ. Улаанбаатар

Influence of teacher's methodology in students writing skills

*Davaasuren.N,
Mongolian National University of Education*

Abstract

The language of mankind has a system of layered layers, an entire system, once the system is systematic and the rule is of a systematic nature, it is essential that the method of teaching is also systematic. Therefore, we have assumed that one of the methodologies of teaching based on the systematic nature of the correct writing is the method of teaching based on the “turning point” between the correct writing rules. As we have studied, while teaching some of the rules in the Cyrillic script have been repeated from 2 to 17 times, which creates “turning point” and strengthens relationships between rules. We have tested this methodology in the 2017-2018 academic year for freshmen for the “Correct pronunciation/spelling, correct writing/grammar” program. In order to evaluate our teaching methodology, we conducted survey on October 12, 2018 after five months of organizing our training. Thirty three students out of one hundred and twenty who attended the training were chosen randomly to participate in the survey. Survey was taken based on the results of “Correct pronunciation/spelling, correct writing/grammar” program, which aimed to identify fifteen abilities of students. The abilities include: learn how to give justified explanation of writing grammar, identify wrong or correct writing, correct the mistakes, write without errors, apply the ability of teaching writing skills, all these were included in the package of assignments. Average score of the survey reached 71 (C-), one can say the score is low, on the other hand, this was the result of 16 hours program and the survey was taken after five months since the completion of the program and in this case we can say results were satisfactory. This study demonstrates that the proper guidance or methodology of the teacher provides support in learning, as well as avoiding memorizing the rules without full understanding and refusing to teach separately, relationship between the rule of writing/grammar, all these are fundamental in strengthening grammar knowledge, proper understanding of grammatical rules, improving ability and practices.

Keywords

Writing Rule, integration, rule frequency, and ‘TURNING POINT’